	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Ёс зүйн дүрэм	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19




“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн хурлын  
21/04 дугаартай тогтоолын Хавсралт №2

### ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Баримт бичгийн нэр	Ёс зүйн дүрэм
Хувилбарын дугаар:	1.0
Баримт бичгийн төлөв:	Хүчин төгөлдөр
Хэлэлцэж эцэслэсэн :	2021/03/12 (ОУСК-Ажлын хэсгийн хурал)
Батлагдсан:	2021/03/19 (Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 21/04 дугаар тогтоол)
Эргэн хянах:	2022/03/20 (Хянан нийцүүлэлтийн газар)
Боловсруулсан нэгж:	ТУЗ-ийн ажлын алба
Хяналт тавих:	ТУЗ-ийн дэргэдэх НДШУХ
Хамаарах компани/нэгж:	Компанийн ТУЗ, түүний дэргэдэх хороод, Гүйцэтгэх удирдлага, бүх газар нэгж, ажилчид болон гэрээт ажилчид, үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутан

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбарын дугаар	Батлагдсан огноо	Товч утга	Боловсруулсан нэгж
1.0	2021/03/19	ОУСК-ийн өгсөн зөвлөмжийн дагуу ТУЗ-ийн ёс зүйн дүрэм болон Ажилтны ёс зүйн дүрмийг нэгтгэн батлав.	ХНГ, ТУЗАА

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Ёс зүйн дүрэм	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

## ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### 1. ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү Ёс зүйн дүрмийн (цаашид “дүрэм” гэх) зорилго нь компанийн эрх бүхий албан тушаалтан болон үндсэн, гэрээт, туршилтын хугацааны ажилтан, дадлага хийж буй оюутнууд (цаашид хамтад нь ажилтан” гэх)-ын компанийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүй хэм хэмээг тогтоон хэвшүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү дүрэм нь “МИК Холдинг” ХК, түүний охин компаниуд, цаашид үүсгэн байгуулагдах охин компаниудын эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад хамаарна.

### 2. КОМПАНИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

#### Шударга, ёс зүйтэй байна

Бусдын итгэлийг дааж, аливаа асуудалд үнэнч шударга хандана;

#### Манлайлал

Цаашид хөгжих боломжийг тодорхойлж бусдадаа ойлгуулан дэмжлэгийг авч хамтдаа бодит үйл хэрэг болгодог;

#### Багын сэтгэлгээ

Харилцан итгэлцэл хүндлэл, дулаан харилцааг буй болгож бүтээлчээр хамтран ажиллах;

#### Мэргэшсэн өндөр чадавхи

Мэргэжлийн өндөр ур чадвартай, өөрийгөө байнга хөгжүүлдэг;

#### Нийгмийн хариуцлага

Нийгмийн хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахыг эрхэмлэж аливаа төсөл санаачилгыг дэмжин ажиллана.

### 3. КОМПАНИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

Компанийн ажилтнууд нь компанийн үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

#### 3.1. Бид ажлын байрандаа:

##### Ажлын орчин


- Аливаа асуудлаар ялгаварлан гадуурхал, сүрдүүлэг хүчирхийллээс ангид ажлын байрыг бүрдүүлнэ.
- Ажлын цагаар ажлын байран дээр ажлын бүрэн чадавхтай байж согтууруулах ундаа, мансууруулах бодисоос ангид байна.

##### Ажилтны биеэ авч явах байдал

- Ажлын байрандаа болон ажлаас гадуур байхдаа биеэ зөв зохистой авч явах.
- Ажил хэрэгч цэвэр цэмцгэр хувцаслана.
- Бие биенээ хүндэтгэн багаар ажиллана.
- Ажил сайжруулах арга замыг байнга илэрхийлж шинийг санаачилж ажиллана.

##### Ашиг сонирхлын зөрчил

- Ашиг сонирхлын зөрчлөөс ямагт ангид байна.
- Компанийн эрх ашгийг хувийн эрх ашгаас ямагт дээгүүр тавьж ажиллана.

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Ёс зүйн дүрэм	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

- Ашиг сонирхлын зөрчил үүссэн үүсэж болзошгүй нөхцөлд энэ тухай удирдлагадаа мэдэгдэнэ.

#### Зөрчил дутагдлыг мэдэгдэх зарчим

- Ажилчид болон оролцогч талуудын гомдол хүсэлт, өргөдөл гаргах эрхийг хүндлэн аливаа асуудлыг нээлттэй шийдвэрлэнэ.
- Албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

#### Компанийн өмч хөрөнгийг ариг гамтай ашиглах зарчим

- Компанийн эд хөрөнгө, техник хэрэгслийг ариг гамтай зөвхөн компанийн албан хэрэгцээнд ашиглана.
- Компанийн ноу-хау, / бизнес модель / оюуны өмчтэй холбоотой эрхийг хувийн болон бусад этгээдийн үйл ажиллагаанд ашиглахгүй.

#### Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглах зарчим

- Олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгнө.
- Компанийн ажилтны хувьд олон нийтийн сүлжээнд компанийн талаар сөрөг мэдээлэл тараахгүй, ёс зүйтэй байна.
- Компанийн нийтэд хүртээмжтэйгээс бусад мэдээллийг тараахгүй байх.

#### Улс төрийн эрх, эрх чөлөө

- Улс төрд иргэний хувьд оролцох эрх нээлттэй.
- Харин компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх.

#### Удирдах ажилтны баримтлах зарчим

- Компанийн удирдах ажилтнууд компанийн үнэт зүйлс, соёлыг хэвшүүлэхэд ажилчдадаа үлгэр дуурайлал үзүүлэн ажиллана.
- Бүх ажилтнууддаа хүндэтгэлтэй хандаж аливаа асуудлаар ялгаварлан гадуурхахгүй, дарамт үзүүлэхгүй, эрх хэмжээгээ буруугаар ашиглахгүй.
- Ажилтны ажлын гүйцэтгэлийг баримттай, бодитой үр дүнгээр шударга үнэлж дүгнэх.
- Хамт олныг хагалан бутаргах ажлын уур амьсгалыг зориуд эвдэхгүй.
- Ажилтантай холбоотой аливаа асуудлыг хов жив цуу ярианд үндэслэн шийдвэрлэхгүй.

#### Хууль тогтоомжийг дээдлэх зарчим


- Монгол улсын хууль тогтоомж зохицуулагч байгууллагын журмыг чандлан баримталж ажиллана.

#### Хувийн бизнес эрхлэх болон бусад байгууллагад ажил эрхлэх

- Компанитай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагад давхар ажил эрхлэхгүй.
- Ажилтнууд чөлөөт цагаараа бусадтай хамтран ажиллаж, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.
- Эрх бүхий албан тушаалтан нь нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтаа гаргаж өгөх үүрэгтэй.

#### Шийдвэр гаргалт



	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Ёс зүйн дүрэм	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

- Компанийн үнэт зүйлсэд суурилсан ёс зүйтэй шийдвэр гаргана.
- Өөрсдийн шийдвэр үйлдлийн төлөө хариуцлага хүлээнэ.

### 3.2. Бид салбартаа

#### Авлига хээл хахуулаас ангид байх

- Ажил үүргээ гүйцэтгэхдээ авилга, хээл хахуул өгөхгүй авахгүй. Ийм санал хүлээн авсан ажилтан энэ тухай өөрийн удирдалагад нэн даруй мэдээлнэ.

#### Бэлэг, даяллага

- Ажил үүргээ гүйцэтгэхдээ тэднээс шан харамж, хэт өндөр дүнтэй бэлэг, хөнгөлөлттэй үйлчилгээ зээл авахгүй.
- Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор бусдад өгөх болон бусдаас хүлээн авах бэлэг нь бизнесийн үйл ажиллагаанд байхвал зохих хэмжээнээс хэтрэх ёсгүй.

#### Мэдээллийн аюулгүй байдал

- Бусдын оюуны өмчийн эрх, мэдээллийн нууцад хүндэтгэлтэй хандаж задруулахгүй байх үүргээ хэрэгжүүлнэ.

#### Байгаль орчинд ээлтэй байх

- Хог хаягдлыг багасгаж усыг ариг гамтай хэрэглэж агаарын бохирдлыг бууруулах зэрэгт чиглэсэн бүтээгдэхүүн техник технологийг ашиглаж нийгмийн хариуцлагаа, нийгэмд гүйцэтгэх үүргээ ухамсарлан ажиллана.

#### Тайлан мэдээ

- Аливаа тайлан мэдээ болон бусад мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв нягт нямбай гаргаж тайлагнах үүрэгтэй.
- Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатай болон санамсаргүйгээр нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл явцад саад учруулахгүй байна.

#### Төрийн байгууллагатай харилцах харьцаа


- Төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр стандарт, дүрэм журмыг мөрдөнө.
- Бизнесийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг эрх бүхий байгууллагад хуулийн дагуу гаргаж өгнө.

#### Харилцагч

- Компани нь харилцагчтай хүндэтгэлтэй ялгаварлан гадуурхахгүй харьцаж аливаа гомдол хүсэлтийн шуурхай шийдвэрлэнэ.

## 4. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ


- 4.1. Ажилтан Ёс зүйн дүрмийг зөрчсөнөөс компанийн эрх ашиг, нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд Хөдөлмөрийн дотоод журмын дагуу арга хэмжээ авна.
- 4.2. Ёс зүйн дүрэм зөрчсөн талаарх гомдлыг амаар болон бичгээр авна. Мөн зөрчлийн талаарх мэдээллийг тусгайлсан шугамаар хүлээн авна.
- 4.3. Эрх бүхий албан тушаалтны ёс зүйн зөрчлийг ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хороогоор хэлэлцэнэ.
- 4.4. Ажилтны ёс зүйн зөрчлийн талаар гомдол мэдээллийг хүлээн авч, үндэслэлийг шалган тогтоох үйл ажиллагааг Ёс зүйн хороо хариуцах бөгөөд үйл ажиллагааг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан тусгайлсан журмаар зохицуулна.

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Ёс зүйн дүрэм	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

## 5. БУСАД

- 5.1. Энэхүү дүрмийн хэрэгжилтийг компанийн Комплаенсийн үйл ажиллагаа хариуцсан нэгж улирал бүр ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хороонд компанийн Гүйцэтгэх захирлаар дамжуулан тайлагнана.
- 5.2. Комплаенсийн үйл ажиллагаа хариуцсан нэгж энэхүү дүрмийг жил бүр эргэн хянаж нэмэлт, өөрчлөлт оруулах, эсвэл шинэчлэх шаардлагатай тохиолдолд төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтан болон нэгжээс санал авч Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулна.

\_\_\_000\_\_\_

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Ёс зүйн дүрэм	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19